



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛГЭ,
ГЕӨДЦЭН, ЗУРАГ ТҮҮН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШЛАЛ

2017-ын 11 сарын 10-ны

Дугаар 8/268

Уснахадан нь

Заавар батлах тухай

Монгол улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дахь хэсэгт, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.21 дахь залгын тус Газрын даргын дэргэдэх эзэмшлийн 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хурлын 07 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Балчазарийн экологийн чадвахийг зураглах зааврыг хансрантасаа баталсугай.
2. Энэхүү зааврын дагуу балчазрийн экологийн чадвахийн зураглалыг аймгийн хөмжээнд 2020 он хуртгал бүрэн боловсруулж, газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг аймгуудын Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт үүргээ болгосугай.
3. Зааврыг орон нутагт мөрдүүлэхад мэргэжил арга зүйгээр хангах ажиллахыг Газар зохион байгуулалтын хэлтэс АК.Батсайхан/-т, тушаалын хэргийнхэд хянжлэл тавыж ажиллахыг Засиргаа, удирдлагага, хамтын ажиллагааны газар /Р.Гангуяа/-т тус тус давтгасугай.

ДАРГА

ЦГАНХҮҮ



08 00950

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн
газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 10-ны
едрийн **9/268** дугаар тушаалын хавсралт

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. БЭЛЧЭЭРИЙН ЭКОЛОГИЙН ЧАДАВХЫН ЗУРАГЛАЛЫН ТУХАЙ

Бэлчээрийн экологийн чадавх гэж ашиглалтын нөлөөнд үзүүлэх хариу үйлдэл, ургамалжилтын төрөл, зүйл, бүтээмж нь бусад газруудаас ялгагдахуйц өвөрмөц, хөрс, өндөршил, уур амьсгал зэрэг физик шинжээр онцлог тодорхой нэгэн орон зайг хэлнэ. Энгийнээр бол экологийн чадавх бүтээмжийн хувьд ижил орон зай гэсэн уг мөн. Экологийн чадавхыг тодорхойлсны гол ач холбогдол бол байгалийн нөөц, түүний дотор бэлчээрийн экологийн чадавх, даац багтаамжид суурилсан ашиглалтыг нэвтрүүлэх явдал мөн.

Бэлчээрийн экологийн чадавх нь бэлчээрийн газрын гадаргын хэлбэр, хөрс, ургамалжилт, уур амьсгалын онцлогоор экологийн чадавхын бүлгүүдэд хуваагдаж, эн нь төлөвлөлт болон мониторингийн үнэлгээний мэдээллийг боловсруулах сурье болдог.

Швейцарийн хөгжлийн агентлагийн "Ногоон алт" теслийн хүрээнд бэлчээрийн экологийн судалгааны багаас УЦУОСМХ, ГЭБГЭЗГ-ын мэргэжилтнүүд болон ШУА-ийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн, ХААИС-ийн эрдэмтэд, зөвлөхүүдтэй хамтарч боловсруулсан "Монгол орны бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загвар нь 2015 онд баталгаажсанаар эдүгээ улсын хэмжээнд бэлчээр ашиглалтыг төлөвлөх, бэлчээрийн төлөв байдлыг үнэлж, хянах арга хэрэгслэл болон ашиглагдаж байна. Уг загварт Монгол орны зонхилох бэлчээрийг экологийн чадавхаар нь 25 бүлэгт ангилж, бүлэг тус бүр дээр төлөв байдлын шилжилт өөрчлөлтийг сайжруулах зөвлөмжийн хамт загварчилсан байdag.

Бэлчээрийн тогтвортой ашиглалтыг хэрэгжүүлэхэд газар нутгийн онцлог, экологийн чадавх, бүтээмжит чанар, нөхөн сэргээх шаардлага зэргийг судалж хэрэгжүүлэх нь чухал байdag.

Цаашид сумын нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон бэлчээрийн төлөв байдлын мониторинг хийхэд зайнлас тандан судлалын аргаар боловсруулсан орон зайн болон цаг хугацааны өргөн агуулгатай хиймэл дагуулын мэдээг ашиглан боловсруулсан бэлчээрийн экологийн чадавхын зураглалыг /цаашид "Чадавхын зураглал" гэх/ өргөнөөр ашиглах хэрэгцээ шаардлага үүсч байна.